



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**МАНДАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ ЧҮЛТЭМИЙН МАШБАТ
ТАНАА**

2024.09.03 № ГНАГ-2024/13-МТА-НА-205
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч Чүлтэмийн Машбатын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн

018021100

төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Чүлтэмийн Машбат /РД:М370070631/-ын Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Чүлтэмийн Машбатын мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.


Хувийг: Мандал сумын сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**МАНДАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ТӨМӨР ЗАМЧДЫН 1 ДҮГЭЭР БАГТ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ЧҮЛТЭМИЙН МАШБАТЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



- Нийгмийн тулгамдсан асуудлыг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх оновчтой бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- Сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөлтийн ажлыг дэмжиж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- Сумын ундны усыг цэвэршүүлэх санал, санаачилга гарган холбогдох мэргэжлийн болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.
- Иргэдийн орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлнэ.
- Багийн дэд бүтцийг сайжруулах зорилгоор Төмөр замын 1-р багт 9 км сайжруулсан зам тавих асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.
- Сумын иргэдийн хэрэглээний цэвэр усны асуудлыг шийдвэрлэх зорилгоор Төмөр замын 1-р багт 20 ширхэг гүний худаг шинээр гаргах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- Нутгийн иргэдийг хувийн орон сууцжуулахад шаардлагатай мод, модон материалаар хангах ажлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- Хүүхэд залуучуудын авьяас билгийг дэмжих зорилгоор хөгжмийн сургалт явуулах байр, мэргэжлийн боловсон хүчин, хөгжмийн зэмсгээр хангах асуудлыг бодлогоор дэмжин ажиллана.
- Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, 1-р багт байгаа хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнг бүрэн ашиглалтад оруулах санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар иргэдтэй хамтарч 96 айлын тоглоомын талбайг сэргээн тохижуулж, 36, 45, 43-р байрыг пасаджуулахад анхааран ажиллана.
- Ногоон байр болон чулуун байруудын цэвэр бохирын шугамын асуудлыг шийдэхэд онцгойлон анхаарч ажиллана.
- Хүүхэд залуучууд, иргэдэд дурсамж болон уламжилж ирсэн “Түүх мартаггүй” тэмдэглэлт өдрийн хамрах цар хүрээг нэмэгдүүлэн тус суманд амьдардаг орос иргэдийг дэмжин ажиллана.